



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Эрүүгийн хэрэг¹)

ГЭМ БУРУУГИЙН ХЭЛБЭРИЙН ТАЛААР МАРГАСАН ТОХИОЛДОЛД ГЭМ БУРУУГАА ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН ГЭЖ ҮЗЭХГҮЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2024/ХШТ/19

Шүүхийн шийдвэрийн огноо: 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалыг тус тус хүчингүй болгосон.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Шүүгдэгч нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ Б-тай маргалдаж, улмаар зүүн эгэм хэсэг рүү нэг удаа хутгалж, түүнийг алсан гэмт хэрэгт холбогджээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- Анхан шатны шүүхээс** шүүгдэгчийг хүнийг алах гэмт хэрэгт гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1.4 дэх хэсэгт² заасныг баримтлан тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт³ зааснаар 6 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан.
- Давж заалдах шатны шүүхээс** анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 1 дүгээр заалтыг “Шүүгдэгчийг “хүнийг алах” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсугай” гэж өөрчилж, тогтоох хэсгийн бусад заалтыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.
- Хяналтын шатны шүүхэд хохирогчийн өмгөөлөгч гаргасан гомдолдоо** “...шүүгдэгч нь өөрийн үйлдсэн хэргийн талаар нэг ч удаа сайн дураар мэдүүлээгүй, хохирогчид анхны тусламж үзүүлэх, амь насыг аврах ямар ч оролдлого хийгээгүй, хэргийн газраас зугтаж явж, хохирогчийн үхлийн талаар огт өөр зүйл бусдад ярьсан болон шүүгдэгчийн өмгөөлөгч шинжээчийн дүгнэлт үндэслэлгүй гэх мэтээр удаа дараа маргаж, шүүх хуралдаанд гэм буруугийн асуудлаар маргаж оролцсон нь шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

https://www.shuukh.mn/single_case/3528?daterange=2020-01-01%20-%202025-10-08&id=3&court_cat=2&bb=1

² Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.4 дэх хэсэг “энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг арван хоёр жил, эсхүл арван таван жил хүртэл хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн бол тухайн зүйл, хэсэг, заалтад заасан ялын дээд хэмжээний гуравны хоёроос хэтрүүлэхгүйгээр, ялын доод хэмжээний гуравны хоёроос багагүй ял оногдуулах”

³ Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Хүнийг алсан бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”



буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрч, гэмт хэрэг үйлдсэндээ гэмшсэн гэсэн анхан шатны шүүхийн дүгнэлт үндэслэлгүй. Иймд шийтгэх тогтоол, магадлалыг тус тус хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

4. **Хяналтын шатны шүүхээс** Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйл⁴ нь **шүүхэд үүрэг болгосон бус эрх олгосон заалт тул эрүүгийн хариуцлага хүлээлгэх нийтлэг үндэслэл болон эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдлын хүрээнд дээрх зохицуулалтуудыг хэрэглэх эсэх нь шүүхийн эрх мэдлийн асуудал** боловч уг зүйлийг хэрэглэх нь мөн хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт⁵ заасан “Шударга ёсны зарчим”-тай нийцсэн байвал зохино.(28)⁶
5. Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх⁷ зохицуулалтаар **тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн тохиолдолд л шүүх уг заалтыг хэрэглэж болохоор хуульчлагдсан** байна.(30)
6. Эрүүгийн эрх зүйн онол, хууль хэрэглээний жишигт **гэм буруугаа хүлээн зөвшөөрөх гэдэгт** тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрч, хэргийн үйл баримт, гэм буруу болон түүний хэлбэр, учирсан хохирол, хор уршиг, тэдгээрийн шинж чанар, хэр хэмжээ, эдгээр нөхцөл байдлын талаар эрх бүхий байгууллагаас хийсэн хууль зүйн дүгнэлт, хэргийн зүйлчлэл зэргийн талаар огт маргахгүй байгааг ойлгодог билээ.(32)
7. Шүүгдэгч анхан шатны шүүх хуралдаанд “...хутгыг нь булаацалдаж байгаад унах явцдаа дүрсэн байсан ...хутгатай гарыг нь бариад арагшаа ойчсон. Би алья гээд санаатай хутга зоож алаагүй” гэж мэдүүлсэн.(33)
8. Гэрчийн мөрдөн шалгах ажиллагааны шатанд “...ноцолдож байгаад Б ах хойшоо хөл алдаад унасан, тэгээд ухасхийгээд босоод ирэх хооронд хар хутгаар Б ахын зүүн эгэм хэсэг рүү хатгачих шиг болсон”, шинжээчийн анхан шатны шүүх хуралдаанд амь хохирогчийн биед үүссэн шархны чиглэл, уг гэмтэл нь хутганы хэдэн удаагийн үйлчлэлээр болон хоёр хүн давхарлаж унах үед үүсгэгдэх эсэх, хэрэв дарж унах үед үүссэн бол ямар шинж тэмдэг илрэх талаар тайлбарлан мэдүүлсэнээр хэргийн үйл баримтын талаарх шүүгдэгчийн дээр дурдсан мэдүүлэг үгүйсгэгджээ.(34)
9. Гэм буруугийн хэлбэрийн талаар шүүгдэгч нь шүүхийн хэлэлцүүлгийн явцад “Би яг санаатай алья гэж алаагүй, дайрч очиж алаагүй, санамсаргүй алсан л гэж үзэж байгаа” гэж мэдүүлсэн.(35)

⁴ Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйл. Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх

⁵ Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна”

⁶ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.

⁷ Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Шүүх гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдал, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлсэн байдлыг харгалзан дараах байдлаар эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлж, эсхүл эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно”



10. Шүүгдэгч нь хэргийн үйл баримт, гэм буруугийн хэлбэрийн талаар маргаж байхад хоёр шатны шүүх түүнийг гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хэмээн дүгнэж Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.4 дэх хэсэгт заасныг баримтлан эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлсэн нь буруу бөгөөд энэ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.7 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт⁸ заасны дагуу Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн нөхцөл байдалд хамаарч байх тул анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн гомдол, магадлалыг тус тус хүчингүй болгож шийдвэрлэжээ.(36)

---oOo---

⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.7 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэг “хуулийн зүйл, хэсэг, заалтыг буруу тайлбарлаж хэрэглэсэн”